ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/122/НА-СТА-ТШЗ**

---


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Л.Баянмөнх
Утас: 99997540
Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 2

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 4

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** ..... 4

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** ..... 5

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** ..... 6

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** ..... 8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** ..... 9

**3..1 Албан шаардлага** ..... 10

**3.2 Зөвлөмж** ..... 11

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.25 № 63

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Н.ДОЛГОРСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 16 нэр төрлийн үндсэн хөрөнгөд 36,047.6 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 4.0 дахин их байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т (*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*) заасныг мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад үйл ажиллагааны орлого өмнөх оноос 95.4 сая төгрөгөөр буурсны дийлэнх хувийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого (үндсэн хөрөнгө)-ын бууралт, үйл ажиллагааны зардал 137.2 сая төгрөгөөр өссөний дийлэнх хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал эзэлж байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

4826050210

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилт, 28 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар Говь-Угтаал сумын засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 95.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **150,637,054.75** | **99,951,443.50** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2,207,412.70 | 1,290,266.47 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 2,207,412.70 | 1,290,266.47 |
| **3121** | **Төгрөг** | 2,207,412.70 | 1,290,266.47 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,455,208.70 | 1,290,266.47 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 752,204.00 | - |
| **33** | **АВЛАГА** | 72,876,147.72 | 17,772,152.60 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 469,345.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 72,406,802.72 | 17,019,948.60 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 752,204.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 75,553,494.33 | 80,889,024.43 |
| **351** | **Түүхий эд материал** | 38,489,477.83 | 41,149,423.53 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 32,647,895.66 | 25,670,393.53 |
| 35130 | Эм боох материал | 5,841,582.17 | 15,479,030.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | - |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 37,064,016.50 | 39,739,600.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 234,800.00 | 773,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,833,076.50 | 35,571,950.90 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 25,000.00 | 25,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 214,200.00 | 261,250.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 99,000.00 | 1,649,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 657,940.00 | 1,458,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **523,985,321.76** | **435,440,252.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 523,985,321.76 | 435,440,252.33 |
| **392** | **Биет хөрөнгө** | 496,534,321.76 | 408,156,960.63 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 347,972,345.00 | 347,172,345.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (69,747,066.41) | (80,685,694.67) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 92,536,434.00 | 61,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (33,398,424.52) | (48,580,627.42) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 216,836,124.05 | 233,484,119.05 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (113,008,963.54) | (143,281,490.12) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,042,467.76 | 42,832,354.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,119,500.02) | (18,622,203.30) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 41,061,413.46 | 40,561,413.46 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (18,640,508.02) | (26,523,256.13) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 27,451,000.00 | 27,283,291.70 |
| 39301 | Програм хангамж | 805,000.00 | 805,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (167,708.30) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,646,000.00 | 26,646,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **674,622,376.51** | **535,391,695.83** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **42,920,119.59** | **29,172,680.71** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 42,920,119.59 | 29,172,680.71 |
| **413** | **Өглөг** | 42,920,119.59 | 29,172,680.71 |

| | | | |
|---|---|---|---|
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,248,216.00 | 12,523,140.71 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 14,688,059.59 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 22,983,844.00 | 16,649,540.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 22,983,844.00 | 7,295,540.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 9,354,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **631,702,256.92** | **506,219,015.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 631,702,256.92 | 506,219,015.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 339,644,471.44 | 339,644,471.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 339,644,471.44 | 339,644,471.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 204,935,875.59 | 79,452,633.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 204,935,875.59 | 204,935,875.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (125,483,241.80) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 87,121,909.89 | 87,121,909.89 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **674,622,376.51** | **535,391,695.83** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **909,317,877.83** | **813,912,170.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **130,903,376.17** | **30,499,423.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 130,903,376.17 | 30,499,423.90 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 130,903,376.17 | 30,499,423.90 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,202,495.80 | 18,123,980.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **778,414,501.66** | **783,412,746.20** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 54,898,500.00 | 51,100,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 54,898,500.00 | 51,100,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 723,516,001.66 | 732,312,246.20 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 723,516,001.66 | 732,312,246.20 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **769,018,962.37** | **906,176,223.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **769,018,962.37** | **906,176,223.64** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 768,660,723.36 | 855,698,023.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 457,064,457.00 | 550,221,807.15 |
| 210101 | Үндсэн цалин | 292,790,752.00 | 322,531,885.00 |
| 210102 | Нэмэгдэл | 136,241,129.00 | 180,590,306.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,045,000.00 | 16,624,440.00 |
| 210104 | Урамшуулал | 23,987,576.00 | 30,475,176.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,935,308.22 | 67,358,912.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,671,027.39 | 47,367,643.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,649,844.57 | 5,593,281.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,857,947.90 | 2,322,856.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,431,797.53 | 9,324,031.07 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,992,194.99 | 32,296,868.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,048,460.99 | 3,953,134.87 |
| 210302 | Түлш, халаалт | 27,943,734.00 | 27,943,734.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,121,584.00 | 25,637,580.86 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,260,000.00 | 1,923,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,890,170.00 | 10,678,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,629,400.00 | 1,901,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 356,400.00 | 528,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,797,352.00 | 4,122,980.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,188,262.00 | 6,482,600.86 |
| **2105** | **Нормативт зардал** | 82,334,169.35 | 60,065,650.94 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 76,598,069.35 | 53,827,838.94 |
| 210502 | Хоол, хүнс | 5,736,100.00 | 6,237,812.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,277,350.00 | 15,029,120.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,277,350.00 | 15,029,120.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,941,000.00 | 8,120,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,941,000.00 | 8,120,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,537,115.00 | 4,224,642.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 881,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 2,016,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,925.00 | 290,610.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,100.00 | 112,832.80 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,261,000.00 | 836,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 216,090.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 73,457,544.80 | 92,743,440.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,085,500.00 | 870,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 68,372,044.80 | 91,873,440.17 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 358,239.01 | 50,478,200.13 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 44,802,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 17,808,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 26,994,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 358,239.01 | 5,676,200.13 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **140,298,915.46** | **(92,264,053.54)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,994,814.34 | 33,219,188.26 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,994,814.34 | 6,766,702.06 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 26,452,486.20 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (1,994,814.34) | (33,219,188.26) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **138,304,101.12** | **(125,483,241.80)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **704,679,707.74** | **857,289,245.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,202,495.80** | **18,489,645.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,202,495.80 | 18,489,645.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,202,495.80 | 18,489,645.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,202,495.80 | 18,489,645.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **701,477,211.94** | **838,799,600.32** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 54,898,500.00 | 51,100,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 54,898,500.00 | 51,100,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 646,578,711.94 | 787,699,100.32 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 646,578,711.94 | 787,699,100.32 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **696,714,506.62** | **829,756,391.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **696,714,506.62** | **829,756,391.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **696,356,267.61** | **787,879,987.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 447,435,870.50 | 548,054,071.52 |
| 210101 | Үндсэн цалин | 263,622,328.96 | 318,262,885.40 |
| 210102 | Нэмэгдэл | 153,759,789.00 | 194,402,623.57 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,851,515.04 | 16,603,940.00 |
| 210104 | Урамшуулал | 22,202,237.50 | 18,784,622.55 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76,375,000.12 | 76,939,783.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,256,000.12 | 52,703,883.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,030,400.00 | 6,059,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,014,400.00 | 3,029,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,014,400.00 | 3,029,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,059,800.00 | 12,117,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,670,960.99 | 33,424,829.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,048,460.99 | 3,953,134.87 |
| 210302 | Түлш, халаалт | 31,622,500.00 | 29,071,695.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,177,640.00 | 20,091,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 992,400.00 | 2,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,235,650.00 | 11,118,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,629,400.00 | 1,901,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 590,300.00 | 528,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,729,890.00 | 4,542,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 73,425,331.00 | 72,085,940.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 61,059,301.00 | 60,917,309.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,160,030.00 | 7,623,631.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,206,000.00 | 3,545,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23,928,850.00 | 16,626,620.00 |
| 210604 | Урсгал засвар | 23,928,850.00 | 16,626,620.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,309,000.00 | 14,752,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,309,000.00 | 14,752,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,791,815.00 | 5,035,642.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 881,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 2,016,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,925.00 | 290,610.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,100.00 | 112,832.80 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,050,000.00 | 1,047,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 216,090.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 465,700.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,241,800.00 | 870,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,241,800.00 | 870,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **358,239.01** | **41,876,404.13** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 35,448,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 17,808,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 17,640,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 358,239.01 | 5,676,200.13 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 752,204.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 752,204.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,965,201.12** | **27,532,853.77** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,950,000.00** | **28,450,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,950,000.00** | **28,450,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,950,000.00 | 28,450,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,950,000.00 | 28,450,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(10,950,000.00)** | **(28,450,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (2,984,798.88) | (917,146.23) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5,192,211.58 | 2,207,412.70 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,207,412.70 | 1,290,266.47 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 339,644,471.44 | 87,121,909.89 | 207,179,107.09 | 633,945,488.42 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **339,644,471.44** | **87,121,909.89** | **207,179,107.09** | 633,945,488.42 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **339,644,471.44** | **87,121,909.89** | **204,935,875.59** | 631,702,256.92 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **339,644,471.44** | **87,121,909.89** | **204,935,875.59** | 631,702,256.92 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **339,644,471.44** | **87,121,909.89** | **204,935,875.59** | 631,702,256.92 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (125,483,241.80) | (125,483,241.80) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **339,644,471.44** | **87,121,909.89** | **79,452,633.79** | 506,219,015.12 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 881,653,100.00 | 858,206,391.55 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 881,653,100.00 | 858,206,391.55 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 838,831,100.00 | 816,329,987.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 551,322,300.00 | 548,054,071.52 |
| 210101 | Үндсэн цалин | 337,654,900.00 | 318,262,885.40 |
| 210102 | Нэмэгдэл | 174,717,100.00 | 194,402,623.57 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,950,300.00 | 16,603,940.00 |
| 210104 | Урамшуулал | 21,000,000.00 | 18,784,622.55 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,155,200.00 | 76,939,783.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,919,300.00 | 52,703,883.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,059,000.00 | 6,059,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,029,500.00 | 3,029,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,029,500.00 | 3,029,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,117,900.00 | 12,117,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,100,500.00 | 33,424,829.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,554,200.00 | 3,953,134.87 |
| 210302 | Түлш, халаалт | 27,186,300.00 | 29,071,695.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,360,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,989,300.00 | 20,091,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,400,000.00 | 11,118,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,948,600.00 | 1,901,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 528,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,040,700.00 | 4,542,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 80,813,300.00 | 72,085,940.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 68,813,300.00 | 60,917,309.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,250,000.00 | 7,623,631.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,750,000.00 | 3,545,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 45,901,700.00 | 45,076,620.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,150,000.00 | 28,450,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 16,751,600.00 | 16,626,620.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,082,000.00 | 14,752,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,082,000.00 | 14,752,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,466,800.00 | 5,035,642.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 881,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,016,000.00 | 2,016,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 290,610.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 112,800.00 | 112,832.80 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,050,000.00 | 1,047,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 600,000.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 870,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 870,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 42,822,000.00 | 35,448,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,822,000.00 | 35,448,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 24,822,000.00 | 17,808,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,000,000.00 | 17,640,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 873,855,300.00 | 857,289,245.32 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 51,100,500.00 | 51,100,500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 51,100,500.00 | 51,100,500.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 804,261,700.00 | 787,699,100.32 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 804,261,700.00 | 787,699,100.32 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 18,493,100.00 | 18,489,645.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,821,600.00 | 18,489,645.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 671,500.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 2,207,412.70 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 1,290,266.47 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82,159.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 5,306.7 мянган төгрөгийн алдааг завсрын аудитаар явцад залруулан 40,804.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 36,047.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

1. Ажиллагсадтай холбогдох 469.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулахдаа туслах үйл ажиллагааны орлогоос тохируулах бичилт хийж бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т /*Үнэн зөв байх*/ мөн хуулийн 20.2.4-д /*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*/ заасныг;
2. Үр дүнгийн тайланд 4,837.3 мянган төгрөгийн хангамжийн бараа материалын зардлыг нормативт зардлын ангилалаар зардлын бүлэг хооронд нь гүйлгэн тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т /*Үнэн зөв байх*/ мөн хуулийн 20.2.4-д /*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*/ заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар илрүүлсэн алдаануудыг бүрэн залруулсан.*

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 76,852.4 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 40,804.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 36,047.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

### 3..1 Албан шаардлага

1. Эрүүл мэндийн төв нь 11,632.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалын нөөцийг хэтрүүлэн бүрдүүлсэн байна. Энэ нь Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д /*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;

2. Таван богд нура ХХК-д байгууллагын ажилтнуудыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, шинжилгээ хийлгэж төсвийг үр ашиггүй зарцуулж төсвийн хууль тогтоомжийг зөрчиж 29,172.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 29.6-т /Эрүүл мэндийн ажилтныг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамруулна/ Төсвийн тухай хуулийн 6.4.1 /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/ 6.4.8-т /*төсвийг*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*/ заасныг мөн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна;

*Шийдвэрлэсэн нь:*

Зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ. /Албан шаардлагын хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлэх/

### 3.2 Зөвлөмж

*Илрүүлэлт*

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 16 нэр төрлийн хөрөнгөнд 36,047.6 мянган төгрөгийн элэгдэл тооцож, бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т /*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/ заасныг мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:*

Үндсэн хөрөнгөнд элэгдлийг нөхөн тооцож, санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгсөн. /Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, хэрэгжилтийг 2026.06.01-ний өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх/

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудиттай холбоотой 40,804.8 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь авч үзсэн. Залруулагдаагүй алдаа болох 16 нэр төрлийн үндсэн хөрөнгөд 36,047.6 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй материаллаг алдаа, зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 4.0 дахин их тул “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажиллагсадтай холбогдох авлагыг барагдуулахдаа туслах үйл ажиллагааны орлогоос тохируулах бичилт хийж бүртгэж тайлагнасан. | 1 | 469.3 | | | 1 | 469.3 | 1 | 469.3 | | |
| Үр дүнгийн тайланд хангамжийн бараа материалын зардлыг нормативт зардлын ангилалаар зардлын бүлэг хооронд нь гүйлгэн тайлагнасан. | 1 | 4,837.3 | | | 1 | 4,837.3 | 1 | 4,837.3 | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **5,306.6** | | | **1** | **5,306.6** | **1** | **5,306.6** | | |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 16 нэр төрлийн хөрөнгөнд элэгдэл тооцож, бүртгээгүй. | 1 | 36,047.6 | | | | | 1 | 36,047.6 | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **36,047.6** | | | | | **1** | **36,047.6** | **-** | **-** |

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрүүл мэндийн төв нь 11,632.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалын нөөцийг хэтрүүлэн бүрдүүлсэн байна | 1 | 11,632.1 | | | 1 | 11,632.1 | | | | |
| Таван богд нура ХХК-д байгууллагын ажилтнуудыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, шинжилгээ хийлгэж төсвийг үр ашиггүй зарцуулж төсвийн хууль тогтоомжийг зөрчиж өр төлбөр үүсгэсэн | 1 | 29,172.7 | | | 1 | 29,172.7 | | | | |
| **Дүн** | **2** | **40,804.8** | | | **1** | **40,804.8** | | | | |